

Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наяд төгрөгийн цогц төлөвлөгөө

1

Репо санхүүжилтийн зээл

2

Ажлын байрыг дэмжих зээл

3

Орон сууцны ипотекийн
хөнгөлөлттэй зээл

1

Репо санхүүжилтийн зээл

ЖДҮ болон Уул уурхайн бус экспортын салбар

Зээлийн зориулалт: ЖДҮ-ийн салбар болон уул уурхайн бус экспортын салбарыг дэмжих зорилгоор эргэлтийн хөрөнгө болон хөрөнгө оруулалтын шинэ зээл олгох болон бизнесийн зээлийн үлдэгдлийг дахин санхүүжилт хийх.

- **Зээлийн хэмжээ:** 3 тэрбум хүртэл төгрөг;
- **Зээлийн хугацаа:** 30 хүртэл сар;
- **Зээлийн хүү:** жилийн 10.5% хувь;
- **Зээл төлөх хэлбэр:** Сар бүр тогтмол дүнгээр. Үндсэн төлбөрөөс 6 хүртэл сар чөлөөлөгдөх боломжтой;



Зээлийн шалгуур

- МУ-д үйл ажиллагаа эрхэлдэг МУ-ын иргэн, ААН байх;
- Сүүлийн 6 сар тасралтгүй бизнесийн үйл ажиллагаа эрхэлсэн байх;
- Үндсэн болон хамтран үүрэг гүйцэтгэгчээр орсон үлдэгдэлтэй бүх зээл болон зээлдэгчийн хамаарал бүхий этгээдийн үлдэгдэлтэй зээл ЗМС-ийн лавлагаагаар “хэвийн”-ээс бусад ангилалд ангилагдаагүй байх;
- Шүүхийн шийдвэрийн дагуу төлөх өр, төлбөргүй, дансанд барилт хийгдээгүй байх;



ЖДҮ зээлийн хувьд

- 200 хүртэлх ажилтантай, жилийн борлуулалтын орлого нь 2.5 тэрбум төгрөгөөс доош байх;
- **ААН-н хувьд:** Сарын EBITDA (Хүү, татвар, элэгдэл, хорогдлын өмнөх орлого) нь зээлийн сарын эргэн төлөлтөөс багагүй байх;
- **Иргэдийн хувьд:** Сарын ахиуц ашиг (Борлуулалтын орлогоос хувьсах зардлыг хассан дүн) нь зээлийн сарын эргэн төлөлтөөс багагүй байх;



УУБЭС зээлийн хувьд:

- Сүүлийн 2 жилийн баталгаажсан тайлан, хэрэв 2 жилийн дотор байгуулагдсан бол эхлэлтийн ба байгуулагдсанаас хойш тайлан;



Барьцаа хөрөнгө

- Барьцаанд бүртгэгдэх үед эд хөрөнгө өмчлөх болон эд хөрөнгийн бусад эрхийн талаар гуравдагч этгээдэд барьцаалагдаагүй, шаардах эрх үүсээгүй, шаардах эрхийн зөрчилгүй байх;
- Нийт барьцаа хөрөнгийн зах зээлийн үнэлгээ болон зээлийн харьцаа 143%-иас багагүй байх;
- Хөдлөх эд хөрөнгө барьцаалсан зээлийн хувьд “Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль”-ийн 7-р зүйл[1]-д заасан барьцаа хөрөнгө байх;

2

Ажлын байрыг дэмжих зээл

ЖДҮ болон иргэн

Зээлийн зориулалт: Зээлдэгчийн ажлын байраа хадгалах, бизнесийн үйл ажиллагаагаа тогтвортой явуулахад шаардлагатай эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх.

- **Зээлийн хэмжээ:** ААН бол 500 сая хүртэл төгрөг, Иргэн бол 50 сая хүртэл төгрөг;
- **Зээлийн хугацаа:** 36 хүртэл сар;
- **Зээлийн хүү:** жилийн 3%;
- **Зээл төлөх хэлбэр:** Сар бүр тогтмол дүнгээр. Үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх боломжит хугацаа 12 сар;
- **Батлан даалтын хувь:** 60 хүртэл хувь;
- **Батлан даалтын шимтгэл:** Батлан даасан дүнгийн 1 хувь;



Банкны шалгуур

- Банк, банк бус санхүүгийн байгууллагад хугацаа хэтэрсэн, чанаргүй зээл, хүүний өр төлбөргүй байх;
- Зээлдэгчтэй хамаарал бүхий этгээд нь чанаргүй зээлийн үлдэгдэлгүй байх
- Зээлийн эргэн төлөлтийг хангах орлогын тогтмол эх үүсвэртэй байх;
- Бизнесийн үйл ажиллагааны орлогоос зээлийн төлбөрийг бүрэн төлөх чадвартай байх;
- Сүүлийн 1-2 жилийн дансны хуулга;



Зээлийн шалгуур

- **ААН:** НӨАТ суутган төлөгчөөр бүртгүүлсэн, эсвэл НӨАТ-с чөлөөлөгдсөн байх;
- **Иргэн:** МУ-ын нутаг дэвсгэрт хувиараа аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэг МУ-ын иргэн байх;

Зээлийн батлан даалтад хамрагдах бол:

- 200 хүртэлх ажилтантай, жилийн борлуулалтын орлого нь 2.5 тэрбум төгрөгөөс доош байх жижиг дунд үйлдвэр эрхлэгч ААНэгж байх;
- ЖДҮҮДТ хуулиар хориглосон үйл ажиллагаа эрхэлдэггүй байх /Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 7.1/;
- Зээлдэгчийн барьцаа хөрөнгө хүрэлцэхгүй байх;

- Сүүлийн 1 жил тасралтгүй үйл ажиллагаа эрхэлсэн байх;
- Банкны шаардлагыг хангасан өөрийн өмчлөлийн эсвэл гуравдагч этгээдийн барьцааны зүйл байх ба барьцаа хөрөнгө нь өөр зээлд давхар харьяалагдаж болно;
- Сүүлийн 2 жилийн баталгаажсан тайлан, 2 жилийн дотор байгуулагдсан бол байгуулагдсанаас хойших тайлан;

3

Орон сууцны ипотекийн ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛ

Зээлийн зориулалт: Иргэдийн төлбөрийн чадварт нийцсэн, инженерийн дэд бүтцэд холбогдсон орон сууцаар хангах;

- ♦ **Зээлийн хэмжээ:** Худалдан авах орон сууц 80 м.кв-с хэтрэхгүй байх
- ♦ **Зээлийн хугацаа:** 360 хүртэл сар
- ♦ **Зээлийн хүү:** жилийн 6%
- ♦ **Зээлийн шимтгэл:** Зээлийн нийт дүнгийн 1 хувиас хэтрэхгүй



Банкны шалгуур

- ♦ Барьцаа хөрөнгө нь 49-с дээш жилийн насжилттай бол тухайн орон сууцыг ашиглахыг хориглоогүй, нурж болзошгүй байрны жагсаалтад ороогүй тухай мэргэжлийн хяналтын байгууллагын тодорхойлолт, лавлагаа. *(НЗДаргын захирамжаар дахин төлөвлөлтөд орсон бол зээлээр санхүүжүүлэхгүй байх);*
- ♦ Үндсэн болон хамтран зээлдэгчийн аль нэг нь цалин эсвэл бизнесийн орлогоо сүүлийн 12 сар тухайн банкаар дамжуулсан байх;
- ♦ Орон сууц болон, зээлдэгчийн амь насны даатгалд хамрагдах.
- ♦ Үндсэн зээлдэгч тэтгэвэрт гарах наснаас өмнө зээлийг төлж дууссан байх;



Зээлийн шалгуур


- ♦ 21 нас хүрсэн МУ-ын иргэн байх;
- ♦ 30-аас доошгүй хувийн урьдчилгааг төлсөн байх;
- ♦ Банк санхүүгийн байгууллагад хугацаа хэтэрсэн, чанаргүй зээлийн өрийн үлдэгдэлгүй байх, мөн шүүхийн шийдвэрийн дагуу төлөх өр, төлбөргүй байх;
- ♦ Шинэ зээл олгох;
- ♦ Өр орлогын харьцаа 45%-иас хэтрэхгүй, татварын өмнөх орлогоос тооцно;
- ♦ Үндсэн зээлдэгч өмнө нь төрөөс хэрэгжүүлсэн ипотекийн зээл, түрээслээд өмчлөх орон сууцны хөтөлбөрт хамрагдаагүй байх;
- ♦ Өрхийн орлого нь цалингийн орлогоос бүрддэг бол үндсэн ажилтнаар тасралтгүй 12 (хамтран зээлдэгч нь 6 сар) сараас багагүй хугацаанд ажилласан байх;
- ♦ Өрхийн орлого нь бизнесийн орлогоос бүрддэг бол сүүлийн 12 сараас багагүй хугацаанд тогтвортой үйл ажиллагаа явуулсан байх;
- ♦ Өрхийн орлого нь түрээсийн орлого бол сүүлийн 12 сарын хугацаанд түрээсийн төлбөр хүлээн авсан байх шаардлагатай;
- ♦ Барьцаалбар үйлдэх.

Банкны зээл судлах явц

01

Эдийн засагчдын
ажиллаж буй
горим

5:95




Ажиллаж байгаа
Ажиллахгүй байгаа

02

10 их наядын
хөтөлбөртэй
холбоотойгоор 1
ээдийн засагч
дээр 7 хоногт
ирж буй зээлийн
хүсэлтийн тоо

20-25
харилцагч



03

Цар тахлын өмнө
нэг эдийн засагч
дээр 7 хоногт
ирдэг байсан
зээлийн
хүсэлтийн тоо

4-5
харилцагч



04

Цар тахлын өмнө
нэг зээл судалж
олгоход
зарцуулдаг
дундаж хугацаа

3-20
ажлын өдөр

ЖДҮ бичил, жижиг	3 өдөр
ЖДҮ дунд	7-10 өдөр
Том байгууллага	10-20 өдөр